



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 9 сарын 09 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.4 дэх заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Намаас Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшүүлсэн Дамбадондогийн Баатаржав нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4-т заасан Улсын дээд шүүхийн лавлагаа, 32.2.5-д заасан татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт, 32.2.7-д заасан нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар, 32.2.8, 32.2.9-д заасан цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа зэрэг баримтыг дутуу ирүүлсэн тул нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000207